



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/559

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, 18.6, 60 дугаар зүйлийн 60.1.4, Төсвийн тухай хуулийн 29¹, 57 дугаар зүйлийн 57.1, 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны орон нутгийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналуудыг нэгтгэн боловсруулж, эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн дарга: Г.Гантулга (аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд:
- Б.Ариунболд (аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
 - Б.Одхүү (аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
 - М.Батчимэг (аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
 - Э.Эрдэнэжаргал (аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
 - Ч.Ариун (аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Иргэний танхимын мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: Г.Баасанжаргал (аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

6325010786

2.Орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хууль журмын дагуу сум, агентлагуудаас саналыг авч боловсруулж, эрэмбэлэхийг ажлын хэсэг (Г.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРӨВ-ОЧИР